

International Theatre Institute ITI

World Organization for the Performing Arts



Олон улсын Бүжгийн өдөр 2026–04–29

Захидал бичсэн: Кристал Пайт, Канад улс

Бүжиг дэглээч

Монгол (орчуулга)

2026 оны “Олон улсын Бүжгийн өдрийн захидал 2026”

Кристал Пайт, Канад улс

Хүн хөдөлгөөнд оршдог – бид гараа сунгах, өвдөглөх, толгой дохих, цээжээ тэвхийлгэх, нуруугаа хотойлгох, үсрэх, биеэ сэгсрэх, гараа зангидах, нэгнээ хуруугаараа хатгах, түлхэн холдуулах гэх мэтээр байнга хөдөлгөөн хийж байдаг. Энэ бол хөдөлгөөн, мөн бидний ярьдаг хэл. Энэ бол хэрэгцээ шаардлага, ялагдал, зориг, цөхрөл, хүсэл, баяр жаргал, хоёрдмол байдал, бүхимдал, хайрын тухай бидний бие юу хэлэхийг хүсэж байгаагийн илэрхийлэл. Бид эдгээрийг бодит утгаар нь өөрсдийн биеэр мэдэрсэн учраас эдгээр дүрслэл оюун ухаанд утга учиртай **гэрэлтдэг**, өөрөөр хэлбэл бидний сэтгэл хөдөлдөг.

Бид, та бид бүгдээрээ бүжигчид. Амьдрал биднийг хөдөлгөдөг; амьдрал биднийг *бүжиглүүлдэг*. Амьсгалах мэт хоромхон зуурын, яс мэт бат бөх бүжиг биднээр бүтдэг. Бид орон зайг урладаг. Бид биеэрээ, үггүй хэлээр маш гүн гүнзгий ойлгогдохуйц бичдэг. Бид бүжихдээ өөрсдийн оршин буй орон зайг дотроос нь ч, гаднаас нь ч чимж байдаг.

Амьдрал шиг бүжиг биднийг тухайн мөч бүрд нэг бол бүтээж, нэг бол сөнөөж байдаг. Хайрын нэгэн адил үүнийг учир шалтгааны үүднээс тайлбарлах аргагүй.

Би биеийг *байрлал* гэж боддог; бие махбодыг барьж, хэлбэрт оруулж байдаг байрлал. Ийм учраас бүжихдээ бид тэнд байх оршихуйг бүхэлд нь оролцуулдаг.

Энэхүү захидлыг би 2026 оны эхээр бичиж байна, энэ бол бидний оршин буй дэлхийд дарангуйлал, үймээн самуун, зовлонд төгсгөл үгүй мэт санагдах цаг үе. Өдөр бүр, бид хүн гэгч амьтан нэг нэгэндээ хэчнээн аймшигтай аюул заналхийлэл хийж чадахыг, мөн хүмүүс болоод байгаль дэлхийг үгээр хэлэхийн аргагүй хүчирхийлэх хүчнийг тэтгэдэг, өдөөн түрхирдэг эрх мэдэл, хүч чадлын машин хэрхэн ажиллаж буйг гэрчлэн байна. Иймээс үүнд хариу барихад бүжиг нь энгийн бөгөөд хамгийн хэрэггүй зүйл мэт санагдана. Эрс өөрчлөлт, эдгэрэл үнэхээр амин чухал хэрэгтэй байгаа энэ дэлхийд бүжигч уран бүтээлчид бид юу хийж чадах тухай төсөөлөн бодоход үнэхээр хэцүү.

Гэсэн хэдий ч урлаг бол итгэл найдварын адил хайрын нэг хэлбэр. Бусдын доромжлолыг үл тоон цогтой зогсогч урлаг бол хүний оюуны дархлааг бэхжүүлэгч, эдгээгч эм юм. Аливаа асуудлыг цаг үеийн мэдээ, баримтат хийгээд танин мэдэхүйн мэдээллээс, мөн бусдын болоод нийгмийн/цахим сүлжээний сэтгэгдлээс, элдэв хөдөлгөөн болон эсэргүүцэл тэмцлээс өөрөөр харж – хамтдаа – ойлгох гэж хичээж буй биднийг хүнээр нь байлгадаг хөлөг онгоц бол Урлаг.

Бүтээлч мөн чанараараа бид зориг, сониуч зан, энэрэх сэтгэл хийгээд хамтран ажиллах жижиг үйлдлүүдээрээ дамжуулан итгэл найдвар болоод аливааг эсэргүүцэн амьд үлдэх чадвараа бататгаж байдаг. Бүжгээр, бүжиг бүтээх явцдаа хүн төрөлхтөн бид хамгийн сүүлийн үеийн зүрх шимшрүүлсэн дэлхий дахины бүтэлгүйтлээс хавьгүй илүү гэдгийн нотолгоог олж хардаг.

Гэвч бүжигт ямар ч зөвтгөл, бас ямар ч тайлбар хэрэггүй. Бүжиг биднээр бүтдэг боловч бүжиг бидний өмч биш. Түүнд бидний биед хүслээрээ орших л хэрэгцээ бий. Бүжиг бол яг тэр дотроос бид болон үл мэдэх ертөнц хооронд зуучийн үүрэг гүйцэтгэж, тайлбарлах боломжгүйг илэрхийлэн ойлгуулдаг.

Одоо хэмээх тэрхэн хоромд бий болон замхарч буй гоо үзэсгэлэнгийн эдгээр үл мөр хүний сэтгэлийг хөдөлгөдөг. Бидний биед амилж бас үгүй болох бүжиг бидэнд ямар өчүүхэн түр зуурын болохыг маань сануулахын зэрэгцээ хэрэв бид анхаарч ухаж чадвал сүнсээ, мөн чанараа хоромхон ч болов олж харах боломжийг олгодог билээ.

*Орчуулсан: Н.Болороо,
Олон улсын театрын институтийн Монголын төв*